

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	3-14

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын 14-ний
өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Тасалсан: О.Баасанхүү, Б.Пүрэвдорж, Д.Сумъяабазар, Д.Эрдэнэбат.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн гишүүн Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, Б.Хатантуул нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга С.Бямбацогт танилцуулав.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Б.Жавхлан, Л.Болд, Ж.Батзандан нарын тавьсан асуултад Байнгын

хорооны дарга С.Бямбацогт, дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, Ц.Товуусүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг, Д.Хаянхярваа, Д.Оюунхорол нар үг хэлэв.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Д.Хаянхярваа, О.Содбилэг, Д.Оюунхорол, Ж.Батзандан нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Байнгын хорооноос гаргасан, Төсөлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: Байнгын хорооны ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд юуны өмнө Байнгын хорооны гишүүдийн энэ оройн амгаланг айлтгаад Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт маань өнөөдөр батлагдлаа. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахад үндсэн Байнгын хороо болж эхнээс нь хэлэлцэх эсэхээс нь авахуулаад бид хаваржин, зунжин, намаржин ажиллаж, бас манай Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд маань амжилттай, маш хариуцлагатай ажиллаж, бодлогоо авч гарч, батлуулсанд Байнгын хорооны нийт гишүүддээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн Байнгын хорооны ажлын алба, Улсын Их Хурлын Тамгын газрынхан маань бас маш сайн ажилласан. Тэгээд бүгдэд нь ажлын амжилт хүсье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя. Нэг асуудал байгаа. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Та бүхэнд эцсийн хувилбарыг, төсөл болоод эцсийн хэлэлцүүлэг гэсэн тодорхой танилцуулгыг тараасан байгаа. Өнөөдөр, сая анхны хэлэлцүүлгээр хийсэн асуудал дээрээс тодорхой асуудлууд бас хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн байгаа.

Нэгдүгээрт нь, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Дархан, Эрдэнэт хотын асуудал, Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Оюунхорол нараас тодорхой саналууд гаргаж байсан. Энэ саналуудыг эцсийн хэлэлцүүлгээр анхаараарай гэсэн хуралдаан даргалагч чиглэл өгсөн. Үүний дагуу зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг бэлдсэн байгаа.

Мөн улс төрийн намыг байгуулахтай холбоотой Үндсэн хуулийн 19¹-ийн тодорхой зохицуулалтууд байж байгаа энд. 19¹-ийн хоёр дахь хэсгийг 2028

оноос дагаж мөрдье гэдэг чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсөн. Энэ бол Монгол Улсын иргэд эвлэлдэн нэгдэх, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхтэй, бас тодорхой хэмжээгээр зөрчиж байж болзошгүй, улс төрийн намуудад бас хэтэрхий өндөр босго шалгуур болох тийм асуудал байна гэж бас гишүүд ярьсан. Олон улсын байгууллага, улс төрийн намуудаас иймэрхүү асуудал ярьж байсан учраас үүнийг өнөөдөр хэлэлцэх, дагаж мөрдөх хугацааг нь 2028 оноос болгоё гэсэн саналыг оруулж байгаа юм.

Ингээд танилцуулгыг Та бүхэнд тараасан. Мөн зарчмын зөрөөтэй саналын томьёолол тараагдсан байгаа. Ингээд танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Д.Лүндээжанцан гишүүн. Ж.Батзандан гишүүнээр тасаллаа.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр гээд.

Үүнийг бид ярьж байгаад оруулсан. Харин Засгийн газраас тийм үү, Засгийн газар гээд, яах вэ Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судална гэж байгаа. Тэгэхээр Д.Эрдэнэбат гишүүн бол Дархан, Эрдэнэт хот гэж байхгүй. Аймаг байгаа гээд ингээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Дархан, Эрдэнэтийг гэж хэлбэл яасан юм. Болохгүй юу. Хот гэдгийг хасах уу, хасахгүй юу? Манай энэ хуульчид, би өөрөө хуульч гэлээ гэсэн манай энэ ажлын хэсгийнхэн сайн бодооч. Тийм ээ.

Аймгийг хот болгоно гэхээр бас нэг жаахан тийм байгаа юм. Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгоно. Дархан, Эрдэнэт хот гэж байгаа л даа одоо. Дархан-Уул аймгийн Дархан хотыг, Орхон аймгийн Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох. Тэгэхээр бас ингэнэ зөвхөн Баян-Өндрийг нь хот болгох гэж байна гэж бас яриа гараад байж болох юм. Аймгийг хот болгоно гэхээр бас. Энэ томьёолол дээр бодмоор юм байна гэж.

Хоёр дахь нь. Дараа нь ийм байгаа. Дараа нь шинээр нөгөө Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу яахад бусад хот, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Их Хуралд өргөн мэдүүлэх. Энэ бол томьёоллын хувьд яах вэ боломжтой юм шиг байна.

Тэгэхдээ яг одоо бүгдийг нэг амиар 2020 оны сонгуулийн өмнө хэрэгжүүлнэ гэхэд бас төвөгтэй байгаа юм. Судлах ажлууд гарах байхгүй юу. Шуурхай хийсэн нь дээр. Би асууж байна шүү дээ. Тэгвэл ойлголцлоо.

Дараа нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн энэ заалтыг, намын заалтыг 2028 оноос дагаж мөрдөнө гэхээр байна шүү дээ, бидэнд мэдээлэл өгмөөр байгаа юм. Байнгын хороон дээрээ, ядахдаа бичгээр. Нөгөө ирсэн бичиг. Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагаас

бас нэлээн том бичиг ирсэн гээд надад энэ ажлын хэсгийнхнээс ярьсан байхгүй юу. Яг нүдээрээ үзээгүй. Тэр нь бас манай энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бас Өрнөдөд тийм ээ, муухай харагдуулах. Бас Үндсэн хуулийн. Ардчилсан Үндсэн хууль шүү дээ манайх чинь. Бараг зарим газар үлгэр жишээ болдог Үндсэн хууль. Тэрийг бас нэр хүндийг бууруулах ч байдаг юм уу, хамгийн наад зах нь.

Тэгээд Үндсэн хуультай холбогдуулаад энэ заалт ардчиллаас ухарсан гэдэг юугаар бас эрсдэл учруулах байж болзошгүй учраас үүнийг хойшлуулах нь зүйтэй саналыг дэмжиж байна.

Ер нь улс төрийн намын хууль гаргахдаа үүнийг зохицуулж болмоор байгаа юм л даа уул нь. Ийм л зүйлийг асуулт маягаар асууж байна.

С.Бямбацогт: Эхний асуултад манай Дархан-Уул аймаг, Орхон уул аймаг, Орхон аймгаас сонгогдсон гишүүд маань томьёолол нь хир зэрэг зөв байвал яасан юм. Зүгээр манай манай ажлын хэсгээс Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сумыг гээд оруулчихъя. Тэгээд мэдээж Засгийн газар оруулахдаа тэр бусад сумуудыг нь яах юм. Тийм үү. Зэргэлдээ гэдгээ яах юм уу. Энэ дээр Та бүхэн томьёоллоо ямархуу байвал зөв юм гэдгийг бэлдээдэх. Санал гаргасан гишүүд маань. Манай Дархан хотоос, Эрдэнэт хотоос буюу Дархан-Уул аймаг, Орхон аймгаас сонгогдсон гишүүд маань байж байгаа шүү дээ. Томьёоллоо бэлдээд өгөөч гэж хэлье.

Дараагийн асуудал. Тэр улс төрийн намтай холбоотой нийт сонгогчдын нэг хувиас доошгүй иргэд эвлэлдэн нэгдэж байж улс төрийн нам байгуулна гэсэн заалтыг хэт хатуу заалт болсон байна гэдэг асуудлыг төрийн бус байгууллагууд, улс төрийн намууд, улс төр судлаачид нэлээн ярьж байсан. Зөвшилцлийн ажлын хэсэг дээр би бас энэ асуудлыг эргэж харвал яасан юм бэ гэдэг санал ярьж байсан. Харамсалтай нь тухайн үед олон асуудал ярьж, хэт Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн төслийг задалмааргүй байна гэдэг байдлаар зөвшилцлөөр энэ асуудал яригдаагүй.

Ингээд хэлэлцэж байх явцад, урд шөнө, өнөө өглөө Европын Хамтын Ажиллагаа, Аюулгүй Байдлын Байгууллагаас манай Улс төрийн намын тухай хуулийн төсөлд тодорхой санал, дүгнэлт бэлтгэх явцдаа Үндсэн хуульд орж байгаа энэ заалт чинь бас хүний эрхийг бас хэтэрхий боогдуулсан ийм заалт байж болзошгүй байна шүү. Энийг бас анхаарна уу гэсэн бичиг ирүүлсэн юм байна лээ. Энийг албан ёсоор Улсын Их Хуралд, бидэнд ирээгүй байна. Албан бус байдлаар бид нар авч үзсэн. Тийм болохоор энэ дээр эргэж харъя гэж ярилцаад, энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, улс төрийн намын тухай, улс төрийн намын нэг хувьтай холбоотой заалтыг 2028 оноос эхлэн дагаж мөрдөхөөр хойшлуулбал яасан юм бэ гэдэг томьёоллыг бид бэлдсэн байгаа. Мэдээлэл өгөхөд ийм байна. 01 сарын 01-ээс болно тиймээ.

Болдын Жавхлан гишүүн асуултаа асууя.

Б.Жавхлан: Сая Д.Лүндээжанцан гишүүн миний нэг асуух гэж байсныг асуулаа. Ийм асуулт байна цаг хугацааны хувьд.

Хоёрдугаар зүйл дээр хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр гээд. Энэ хүртэл ямар ч байсан хууль тогтоомжоо эхний хагастаа багтаагаад гаргачих юм байна. Харин Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудал нь өөрөө энэ хугацаандаа багтана гэж байгаа юм уу? Эсвэл цаашаа тэр нь задгай үлдэж байгаа юм уу? Үүнийг юу гэж ойлгох вэ? Нэгдүгээр асуулт энэ.

Хоёрдугаарт асуулт дээр саяын томьёолол дээр Дархан-Уул аймаг, Орхон-Уул аймгийг улсын зэрэглэлтэй болгох гэж найруулаад оруулахад болохгүй юм байхгүй гэж бодож байна. Эхний асуултад хариулт өгөөч. Бүр голтой юм уу.

С.Бямбацогт: Тэгэхээр Дархан хууль тогтоомж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчилнэ гэдэг маань үндсэндээ холбогдох хууль тогтоомжоо шинэчилье.

Одоо Үндсэн хуулийн маань 57.3-т засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр нутгийн иргэдийн саналыг үндэслэх тийм үү энэ процесс нэлээн том юм болно. Тэгээд Засгийн газар өргөн барина. Эхлээд хууль тогтоомжоо ямар ч байсан баталчихъя. Дараад нь иргэдийн саналыг үндэслээд Дархан хот болгох, Эрдэнэт хот болгох асуудлыг дараад нь шийдэх юм байна гэж ойлгоорой. Тэгэхгүй бол үндсэндээ 2020 оны эхний 6 сард багтаад Дархан, Эрдэнэт хот болгох бол бас тийм бололцоо боломж нь хууль тогтоомжийн хувьд боломжгүй байх. Энэ яагаад гэвэл иргэдийн саналыг үндэслэнэ гэсэн үг байгаа.

Л.Болд гишүүн, Б.Жавхлан гишүүн тодруулья гэсэн.

Б.Жавхлан: С.Бямбацогт дарга аа. Энэ асуудлыг яг Үндсэн хууль хэлэлцэж байх үед чуулганы танхимд Улсын Их Хурлын даргаас чиглэл өгч байсан шүү дээ. Энэ асуудлыг хууль тогтоомжийг нь батлаад, хот болгох шийдвэрийг ч гэсэн Засгийн газраас оруулж ирээд эхний хагас жилд баталъя гээд. Ард олон нийт, иргэдийн санал бол сүүлийн 20 жил энэ хуулийг гарснаас хойш л энэ санал явж байгаа, ирж байгаа. Маргааш ч бэлэн байгаа.

Тэгэхээр үүнийг нэг мөсөн хугацааг нь маш тодорхой болгоод оруулбал яасан юм бэ. Сая хууль санаачлагч Д.Лүндээжанцан гуай хэлж байсан шүү дээ. Энэ хугацаанд дотор чинь бүх юм нь багтаж байгаа юм. Тэгж ойлгоно гээд. Та сая өөрөөр тайлбарлачихлаа. Тэгээд яаж ойлгох юм бэ үүнийг?

С.Бямбацогт: Би дахиад Үндсэн хуультай л нийцэж явах ёстой. Тийм үү. Үндсэн хуулиа бид баталчихлаа сая.

Үндсэн хуулийн 57.2-т засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж байгаа юм.

Тэгэхээр эхлээд бид нар энэ хуулийг батлах ёстой. Энэ хууль баталсны дараа 57.3 дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж.

Тийм болохоор эхлээд хууль эрх зүйн орчноо бид нар бүрдүүлэх ёстой. Үүн дээр нь тулгуурлаад Засгийн газар ажлыг зохион байгуулна. Зохион байгуулаад Их Хуралд өргөн барина. Энэ агуулгаараа үндсэндээ орж байгаа. Энэ агуулгаараа орохоор цаг хугацааны хувьд би бол 6 сараас өмнө гэж одоо бас арай амжихгүй болов уу гэж бодож байна. Та бүхэн томьёолол байвал томьёоллоо бэлтгээд өгөөч. Энэ үндсэн хуулийн 57.2. 3 дахь заалтуудыг Та бүхэн бас нэг хараач ээ гэж хэлмээр байгаа юм. Л.Болд гишүүн.

Л.Болд: Миний хувьд Тамгын газар хариулах байх. Нэг чухал асуудлыг хөндмөөр байгаа юм.

Нэгдүгээр хэлэлцүүлэг дээр ШИНЭ намын зүгээс Ж.Батзандан гишүүн бид хоёр санал гаргаад, нэг томьёолол дэмжигдсэн. Тэр болохоор Монгол улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хог хаягдал хадгалахгүй, байрлуулахгүй, дамжуулахгүй гээд. Гэхдээ тэрийг Үндсэн хуульд тусгахааргүй, дагаж мөрдөх хуульд нь тусгая гэж тухайн үедээ шийдэж байсан. Тэгээд төсөл тараачихсан чинь тэр нөгөө заалт маань орж ирээгүй. Тэрийг одоо хамаагүй зарчмын зөрүүтэй санал маягаар оруулмаар байна. Энэ өөрөө бол энэ Үндсэн хууль, Монгол Улсын аюулгүй байдлын асуудал, ард түмэн иргэд бол маш их хүсэн хүлээж байгаа. Маш олон түмний дэмжлэг авсан ийм асуудал байгаа. Тэгээд энэ цөмийн хог хаягдлыг асуудлыг бид одоо энэ Үндсэн хуультайгаа хамт шийдэх ёстой гэж үзэж байгаа шүү. Энэ талаар Тамгын газар хариу өгнө үү.

С.Бямбацогт: Таны санал бол Үндсэн хууль дээр оруулахаар ярьж байсан тэр санал, тийм үү? Тийм. Дагаж мөрдөх журмын тухай хуульд бол яг тийм цөмийн хог хаягдлыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулахгүй гэсэн заалтыг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулах боломжгүй. Үндсэн хууль дээр бол бололцоотой байсан. Хэрвээ байсан бол. Тухайн үед.

Одоо бид нар чинь эцсийн хэлэлцүүлэг дээр хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу л зарчмын зөрүүтэй саналыг хоёр саналыг ярьж байгаа. Өөр саналыг бас дэгийн хуулиар бас ярих боломжгүй. Ж.Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Үе үеийн Засгийн газрууд гадаадын улс орнуудын цөмийн хог хаягдлыг Монголын газар нутагт дээр булшлах тухай нууц гэрээ хэлэлцээрүүд хийж байсан гэдэг мэдээлэл олон байгаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс цөмийн хог хаягдлыг Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх, Монгол Улсын нутагт булах, хадгалахыг хориглох тухай бүрхэг тогтоол шийдвэр бас бий.

Тэгэхээр Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад ШИНЭ намаас энэ заалтыг Үндсэн хуульд оруулж, Монгол Улс цөмийн хог хаягдлаас ангид улс байхаар хуульд зааж өгье гэж маш тодорхой саналыг гаргаж байсан. Тэр үед Улсын Их Хурал дарга болон ажлын хэсгийн ахлагч нар дагаж мөрдөх журмын тухай хуулиудаар энийг зохицуулах боломжтой гэдэг асуудлыг ярьж, тухай үед асуудлыг хойш тавьж байсан. Одоо энийгээ яаж зохицуулах вэ гэдгээ ярь. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хот болгох асуудал дээр орон нутгийн болон улсын статустай хот байгуулах асуудал дээр Баянзүрх, Сонгино хайрхан дүүргийн асуудлыг бас хөндөж тавьсан. Дагаж мөрдөх журмын тухай хуулиараа энэ асуудлыг оруулж өгье гэж бас Улсын Их Хурал дээр эрх баригч намын Бүлгийн дарга болон Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар удаа дараа хэлсэн.

Одоо зөвхөн Дархан, Эрдэнэтийн асуудал яригдаад өнгөрөх нь. Баянзүрх, Сонгино хайрханыхаа асуудлыг ярь. Монгол Улсын хамгийн их хүн амтай, ачааллаа дийлэхгүй байгаа засаг захиргааны хоёр нэгж бол Баянзүрх, Сонгино хайрхан дүүрэг юм. Нэг бол хоёр дүүрэг болгож хуваая. Нэг бол хот болгоё.

Ер нь коммунист улсын нийслэлүүд дүүрэгт хуваагддаг. Эрх чөлөөтэй улсын нийслэлүүд, томоохон хөгжилтэй улс орнуудын нийслэлүүд хотуудад хуваагддаг юм. Одоо энэ чиглэл рүүгээ явъя гэдэг саналаа хэлье. Журмын тухай хуульд бас зохицуулалт оруулж өгөөч гэж хүсэлт тавьж байна.

С.Бямбацогт: Тэр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хог хаягдлыг булшлахтай холбоотой асуудлыг яг журмын тухай хуульд оруулах боломжгүй. Гэхдээ би түрүүн хэлсэн. Энэ асуудлыг тусгайлан авч хэлэлцэх бололцоо бол байгаа, бидэнд.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль дээр бид нар нэгдүгээр зүйлд нь биччихсэн байгаа шүү дээ. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийн баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ гээд.

Тийм болохоор бид нар үндсэндээ бол баталсан хуваарь гэдэг, тэр хуваарь батлахдаа ийм ийм хуулиудыг Үндсэн хуульд нийцүүлж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан ийм ийм хугацаа нь ингэж баталъя гэдэг төлөвлөгөө гарна. Энийг Байнгын хороо хэлэлцэнэ. Энэ үедээ энэ дотор цөмийн хог хаягдлыг булшлахтай холбоотой асуудлыг ойрын үед одоо хуулийг нь баталъя гээд жагсаалтад оруулчихъя. Ийм байдлаар явъя гэж ойлголцъё.

Дараагийн асуудал бол хуралдаан даргалагч бас чиглэл өгсөн. Налайх, Багануур дүүрэг мөн одоо Баянзүрх, Сонгино хайрхан дүүргийн асуудлыг ярих ёстой шүү гэж. Яг энэнтэй холбогдуулаад бид нар урд нь бол зөвхөн Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байсан бол үүнийх нь ар талд нь нэг заалт болгоод бусад хот, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлээрэй гэдгийг бас Засгийн газраас чиглэл болгож байгаа. Ингээд орчхож байгаа болохоор саяны одоо хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу Налайх, Багануур дүүргийн асуудал, Сонгино хайрхан, Баянзүрх дүүргийн асуудал энэ агуулга дотор орчихсон байгаа гэж ойлгож болно.

Манай Ч.Хүрэлбаатар гишүүн ч гэсэн бас бусад аймгууд яах вэ гэсэн асуудал ярьсан. Аймгуудын асуудал ч гэсэн 21 аймгийг хот болгох асуудал энд орж байгаа гээд ойлгочихъё. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Байнгын хороо сая хуралдаан даргалагчаас өгсөн саналын дагуу хоёр санал байгаа. Байнгын хороо санал оруулах гэж байгаа. Энийг Та бүхэн бас анхаараад санал хураалгачихъя. Гуравны хоёр.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дэх хэсэгт заасны дагуу бусад хот, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан Байнгын хороо.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Дараа нь та хэдийнхийг яачихъя. Наад чинь яг үнэндээ болохгүй байна гээд байна. Л.Болд гишүүн.

Л.Болд: Одоо энэ чигээрээ гарвал энэ чинь ингээд хууль бус шийдвэр гарах гээд байна. Байнгын хороон дарга аа. Дархан, Эрдэнэт гэж хот байхгүй. Байхгүй юмыг бид нар улсын зэрэглэлтэй хот болгох гэж байгаа байхгүй. Энэ өөрөө яавч байж болохгүй. Харин өнөөдөр юу байгаа вэ гэхээр Дархан-Уул аймаг гэж байгаа. Орхон аймаг гэж байгаа.

Тэгэхээр Орхон аймаг, Дархан-Уул аймгийг улсын зэрэглэлтэй хот болгох гэж орж байж энэ чинь дараа нь хэрэгжих бололцоотой.

Ж.Батзандан: Эсвэл Дархан-Уул аймаг, Орхон-Уул аймагт улсын зэрэглэлтэй хот байгуулах гэж юм бичээч.

Л.Болд: Үгүй, үгүй. Энэ чинь хот байсныг аймаг болгочихсон байхгүй юу. Одоо аймаг болгосныгоо буцаагаад хот болгох гэж байгаа юм. Улсын зэрэглэлтэй хот болгох гэж байгаа юм. Тийм учраас одоо байгаа яг албан ёсныхоо нэгжээ өөр статус руу шилжүүлэх гэж заалтаа хийхгүй бол энэ ямар ч тийм, дараа нь хууль зүйн зөрчилд орно шүү.

С.Бямбацогт: Ц.Товуусүрэн гуай. Одоо манай дэд ажлын хэсгийн ахлагчаас асуугаадахъя би. Дархан хот гэж яагаад бичсэн юм бэ? Дархан хот гэж ямар ч статус байхгүй шүү дээ. Тэгж байгаад хууль бус юм ороод ирлээ гэдгийг Л.Болд гишүүн асууж байна. Тэгэхээр Дархан хот байж болмооргүй байна гэж байна.

Хоёрдугаарт нь, Дархан-Уул аймгийг гээд явахаар бас аймгийн асуудал гэж бид нар бүхэл бүтэн аймгаараа хот болох юм уу гэдэг асуудал үүсэж байна. Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум гэдгээр нь орчихвол яасан юм бэ гэсэн саналууд гарч байна. Энэ одоо алинаар нь явбал зөв юм бэ? Ажлын хэсэг. Хоёрдугаар микрофон. Ажлын хэсгийн.

Ц.Товуусүрэн: Одоо засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь бол Дархан-Уул аймаг, Орхон аймаг. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуугаар байгуулагдсан хот нь бол одоо Эрдэнэт хот, Дархан хот хэвээрээ байгаа шүү дээ. Тэнд чинь Дархан сумынх нь Засаг дарга Дархан хотын захирагч, Баян-Өндөр сумынх нь Засаг дарга Эрдэнэт хотын захирагч гээд явж байгаа шүү дээ. Яагаад байхгүй юм гээд байна. Байж байгаа зүйл шүү дээ.

Тэгээд дээрээс нь юу гэхээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудал бол түрүүчийн тайлбарласнаар 57.3-аар ингээд зохицуулагдаад явна. Хотоо өөрчлөн байгуулах, өөрийн удирдлагыг нь сонгох, өөрийн удирдлагад нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг зарим чиг үүргийг нь шилжүүлэх асуудал бол 57.2-н дагуу зохион байгуулагдаад явна.

Тийм учраас Дархан хот, Эрдэнэт хот гэж яриад байгаа юм. Дархан хот, Эрдэнэт хотын өөрийн удирдлагыг зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судалж, өргөн

мэдүүлнэ гээд байгаа шүү дээ. Тийм учраас энэ бол одоо зөв томьёологдсон гэж бодож байгаа. Тэгэхдээ Засгийн газар өргөн мэдүүлэхдээ 57.3 дагуу асуудал оруулж ирж болно. Тэгвэл тэр өргөн мэдүүлсэн үед нь шийдээд явж болно гэж ингэж харж байгаа.

С.Бямбацогт: О.Содбилэг гишүүн.

О.Содбилэг: Энэ яагаад Эрдэнэт, Дарханыхан хот больё гээд байгаа юм бэ гэхээр 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө хот байсан байхгүй юу. Тэрийгээ буцааж сэргээгээд одоо энэ хүмүүс чинь хотод амьдарч байгаа шүү дээ.

Тэгээд энийгээ буцааж хот гэж, улсын чанартай хот болгоё гэж байгаа юм. Тэгэхээр одоо Улаанбаатар шиг нийслэл дүүрэгт ингээд харьяалагдаад, тэгснээрээ төрийн үйлчилгээ иргэддээ илүү сайн хүрдэг больё гэсэн гол санаа нь энд байгаа байхгүй юу. Тэгээд энийг ингэж оруулъя гээд байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би бас нэлээн олон энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн үед олон удаа давтаж ярьсан тэр нь юу вэ гэхээр бүгдээрээ Эрдэнэт, Дархан хот гээд ард түмнээрээ ингээд нэрлэж, хэлж, ярьдаг байж яг аймгаар нь нэрлэх гэхээр Орхон-Уул гээд байхгүй нэрээр нэрлэх жишээтэй. Дархан хот чинь Дархан-Уул гэж байгаа. Тэрнээсээ одоо нэрлэсэн. Эрдэнэт хот чинь Эрдэнэтийн овооноосоо тэр нэрийг нь өгсөн хотууд байхгүй юу.

Энийг нь ингээд энэ 1992 оноос хойш ингээд маш олон жил ингээд Орхон-Уул гэж одоо манай Эрдэнэтийг гишүүд хүртэл ингээд андуурч яриад байна шүү дээ. Энийгээ бас засаад бүгд одоо хэлж заншсанаараа бүр сурснаараа явахад юундаа болохгүй байгаад юм бэ гэдэг бас нэг асуудал байгаа юм.

Хамгийн гол нь улсын чанартай хот болоод төрийн үйлчилгээ иргэддээ илүү сайн хүрдэг больё гэдэг л санаа явж байхгүй юу. Одоо дүүрэг хороонд хуваарилагдаад, тийм ээ. Хуучин бол Эрдэнэт хотын Хялгант хороо гэж байсан. Улаан толгойн сангийн аж ахуй бас хороо шиг ийм харьяа байсан байхгүй юу. Тэгэхээр одоо буцаад яг ингээд дүүрэг, хороо болоод явахад ямар ч асуудалгүй гэж үзээд байгаа юм.

С.Бямбацогт: Бид нар Үндсэн хуулиа л сайн уншмаар байгаа юм. Тийм ээ? Үндсэн хууль дээр чинь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын гэж байгаа. Нэгж дэх. Тийм болохоор бид нар одоо Дархан хотын захирагч, тийм үү? Эрдэнэт хотын захирагч, Баян-Өндөр сумын Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч, Дархан сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч гээд явдаг юм байна шүү дээ. Тийм болохоор энийг улсын зэрэглэлтэй хот болгоё гэж байна шүү дээ.

Д.Хаянхярваа гишүүний микрофон.

Д.Хаянхярваа: Тэгэхээр энд ийм юм байдаг юм л даа. Зүгээр ер нь одоо явж байгаагаараа бол ингэж явдаг байхгүй юу. Дархан-Уул аймгийн Засаг дарга бөгөөд Дархан хотын захирагч гэж. Тэгэхээр бол Дархан хот гэдэг чинь бол одоо байгаа асуудал.

Тэгэхээр ерөөсөө Эрдэнэт, Дарханыг улсын зэрэглэлтэй хот болгох гэдгээрээ л явах нь бол зөв. Яг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ хувьд аймаг гэдгийг чинь хот болгох гэхээр тэгж болохгүй гэдгийгээ яриад байна шүү дээ. Тэгэхээр бид нар бол ерөөсөө л одоо томьёолол дээрээ бол Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох. Тэгээд нөгөө тэрийгээ яг улсын зэрэглэлтэй хот болгоод ярихдаа эрх зүйн өөрчлөлтөө бол тэр нь дээр харин яаж шийдэх вэ гэдгийг ингээд явчих ёстой юм.

С.Бямбацогт: Ингээд тогтчихлоо. Д.Оюунхорол гишүүн. Саяны томьёолол дээр тогтлоо. Гишүүд томьёоллоо бэлдээд наашаа өгчих тэгээд санал хураалгачихъя.

Д.Оюунхорол: Баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох, Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах. “Дүүрэг” гэдэг үг оруулаад өгөөч ээ.

Миний гаргасан үндэслэл бол Баянзүрх дүүрэг бол 370, 80 мянга хүрж байгаа шүү, бараг. Хүн амаараа. Бид нар 360-аар ярьж байгаа. Энэ бол өнөөдөр Улаанбаатар хотод байгаа дүүргийн зохион байгуулалтын хамгийн багаар бодоход 170-аас 200 мянгатай байгаа. Бусад дүүргүүд чинь. Сонгино хайрхан, Баянзүрх дүүрэг хоёр бол 360-аас 70, 80-н мянган хүн амтай. Шилжилт хөдөлгөөнтэйгөө ийм одоо хэлбэлзэлтэй. Хүн амын хэт их нягтаршилтай. Төрийн үйлчилгээ ард иргэддээ хүрч чадахгүй байгаа учраас Баянзүрх дүүргийг хоёр дүүрэг болгож хуваагаад, Сонгино хайрхан дүүргийн хоёр дүүрэг болгож хуваая л гэж байгаа юм. Тэгэхээр томьёолол дээрээ бол бусад хот, дүүрэг, тосгон гээд ганцхан “дүүрэг” гэдэг үг нэмээд оруулаад өгөөч ээ гэж гуйж байна. Тэгэхгүй бол наадах чинь хуваагдахгүй.

С.Бямбацогт: “Дүүрэг” гээд оруулчихаж болох юм байна. Тийм үү? Бусад хот, дүүрэг, тосгон. Ц.Товуусүрэн гуай тайлбарлая. Хоёрдугаар микрофон.

Ц.Товуусүрэн: Энд байна шүү дээ. Би 57.3-ын дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөн байгуулалтыг хийнэ. 57.2-т заасны дагуу гээд энд бичээд байна шүү дээ. Тэгэхээр бол дүүргийг хот болгож хувиргах асуудал, заавал дүүргийг гээд яах юм бэ. Бусад хот, тосгоны тэр одоо өөрийн удирдлагыг

зохион байгуулах гэдэгтээ багтаад явчихаж болохоор байгаа шүү дээ. Тэгээд тэрийг нь улсын зэрэглэл болгох уу? Орон нутгийн зэрэглэлтэй байх уу гэдгийг нь тухайн үедээ Засгийн газар шийдээд өргөн мэдүүлээд ингээд шийдээд явах бололцоо байгаа. Ер нь бол дүүргүүдийг хот болгох асуудал бол энд туссан гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Ц.Товуусүрэн гуай дүүргийг хот болгох гэсэн юм биш ээ. Дүүргээ хуваая гээд байна шүү дээ. Тийм.

Ц.Товуусүрэн: Тэгвэл тусдаа байх хэрэгтэй дээ.

С.Бямбацогт: Оруулчихъя, оруулчихъя. Болох юм байна. Орчихож болох юм байна. Орчихож болох юм байна. Болох юм байна. Орчихсон байгаа. Тосгон орчихсон байгаа. Би одоо саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дэх хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо Болдын Жавхлан, Д.Хаянхярваа, О.Содбилэг, Д.Оюунхорол, Ж.Батзандан нарын гишүүд.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дараагийн санал хураалт.

Санал хураалтын дүн 15 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 93.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Төсөлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн зүйл нэмэх. Санал гаргасан Байнгын хороо.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье.

Санал хураалтын дүн 15 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Сая тэр нэгдүгээр юун дээр 57.2, 3 заасны дагуу гээд явчихаж болох юм байна шүү. Ц.Товуусүрэн гуай. 2, 3. 2, 3 гээд явчихаж болж байна уу? За, Ц.Товуусүрэн гуай. Хоёрдугаар микрофон.

Ц.Товуусүрэн: Энэ саяны энэ бөөнд нь хураасан юмыг хоёр хуваахгүй бол болохгүй. Нэг нь 57.2-ын дагуу, дүүрэг нь 57.3-ын дагуу шүү.

С.Бямбацогт: Хоёр хуваахгүй 57.2, 3-т заасны дагуу гээд явчихъя. Болно биз дээ тэгээд

Ц.Товуусүрэн: Тэгэхээр байна шүү дээ, дарга аа.

С.Бямбацогт: Тэгээд болно. За. 57.2, 3-т заасны дагуу гэж явахаар боллоо. Ингээд санал хураалтын дүнг танилцуулчихсан. Одоо чинь санал, дүгнэлтийг би толилуулчихъя.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

/Гэрээт/

Б.БААСАНЖАВ

/Гэрээт/

Б.УРАНЧИМЭГ